



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 621

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 542,309,910.00 (таван зуун дөчин хоёр сая гурван зуун есөн мянга есөн зуун арав) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132002665

28-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч	Гэрээний дүн /гүйцэтгэлээр/	Капиталжуулах дүн			Хөрөнгө бүртгэх дүн (төгрөг)
					Зээлийн хүү	Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж	ТХНэгжийн зардал	
1	Дулааны шугамын трасс тодорхойлох, гэмтэл саатал илрүүлэх багаж, программ хангамж	GO-CS-6	Энерготех сервис	337,181,818.00	51,209,489.00	3,203,227.00	13,487,273.00	405,081,807.00
2	Дата сервисийн өрөөний засвra, тоног төхөөрөмж сууриалт	W-CS-21	Аббадонконст ракшн	123,263,388.00	7,087,645.00	1,946,534.00	4,930,536.00	137,228,103.00
Нийт дүн								542,309,910.00
								(таван зуун дөчин хоёр сая гурван зуун есөн мянга есөн зуун арав)